


Үндэсний хөгжлийн газрын даргын
2018 оны 07 дугаар сарын 10 өдрийн
А:50 тоот тушаалын хавсралт



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВИЙГ НИЙСЛЭЛТЭЙ ХОЛБОСОН АВТО ЗАМЫН “ШАР ТЭЭГ”-ИЙН УУЛЗВАРААС ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ТӨВ ХҮРТЭЛХ 59.6 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН БАЙНГЫН ХЯНАЛТЫГ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго	Концессын гэрээгээр хэрэгжих Өмнөговь аймгийн төвийг Нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд тавих технологийн хяналтыг олон улсын жишгээр хэрэгжүүлэх, барилгын ажилд тавих техник технологийн хяналтыг сайжруулах, авто замын барилгын ажлын чанарыг дээшлүүлэх, Төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх судалгаа, тайлан бэлтгэх;
Үндэслэл	Концессын тухай хуулийн 6.2.8, 25.1.1 дэх хэсэг, Авто замын тухай хуулийн 21.1, 21.3 дах хэсэг, Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” 264 дүгээр тогтоол, 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Концессоор хэрэгжүүлэх авто замын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 84 дүгээр тогтоолын дагуу байгуулсан концессын гэрээ;
Хугацаа	<ol style="list-style-type: none"> 1. Захиалагч болон Зөвлөхийн хооронд байгуулах гэрээнд хугацааг тодорхой тусгах бөгөөд гэрээнд заасан төлбөрт багтаан Зөвлөх үйлчилгээг үзүүлнэ. 2. Концессын гэрээний дагуу авто замын барилгын ажил эхлэх өдрөөс Зөвлөх үйлчилгээний ажил эхэлж, барилгын ажлын баталгаат хугацаа дуусахад дуусгавар болно. 3. Зөвлөхийн хяналтын баг нь авто замын барилгын ажлын саруудад, барилгын ажил дууссаны дараа улсын комисс ашиглалтанд хүлээн авах хүртэл, мөн баталгаат хугацааны үед тус тус ажиллана.
Ажлын хамрах хүрээ	<p>Зөвлөх үйлчилгээний хяналтын баг нь Концессын гэрээгээр хэрэгжих авто замын барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нарийвчилсан зураг төслийг хянаж, сайжруулалт хийх саналаа Захиалагчид хүргүүлэх; 2. Гүйцэтгэгчээр ажлын тодотгосон, нэгдсэн, дэлгэрэнгүй график гаргуулан хянаж, Захиалагчид танилцуулах; 3. Гүйцэтгэгчийн ажлын төлөвлөгөө, ажиллах хүч, тоног төхөөрөмжийн төлөвлөгөөг хянаж батлах; 4. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн байдлыг шалган, зохих тохиргоо зүгшрүүлэлт хийсэн, ажлын шаардлага хангасан эсэхийг батлах; 5. Гүйцэтгэгчийн байгуулах хяналтын лабораторийн шаардлага хангаж буй эсэхийг шалгаж, ашиглах зөвшөөрөл олгон,

	<p>лабораторийн туршилт, шинжилгээний ажилд өдөр тутмын хяналт тавьж, шинжилгээний үр дүнг баталгаажуулах;</p> <ol style="list-style-type: none"> 6. Гүйцэтгэгчийн чанарын баталгаа, төлөвлөгөөг батлах; 7. Гүйцэтгэгчийн гаргах байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хянан саналаа өгөх; 8. Гүйцэтгэгчийн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг хянан баталгаажуулах; 9. Замын далан, хөлдөлтөөс хамгаалах үе, суурийн дээд ба доод үе, хучлагад ашиглагдах материал, элс-хайрган хольц, битум, эрдэс нунтаг, асфальтбетон хольц, цемент, буталсан чулуу, ус, арматур, төмөр бетон хоолой болон бусад материалуудын эх үүсвэрийг баталгаажуулж, зөвшөөрөл өгөх; 10. Замын трассыг улсын геодезийн өндөржилтийн цэгтэй холбох, завсрын өндөржилтүүдийн цэгүүдийг байгуулах, замын тэнхлэгийн шугамыг тавих зэрэгт хяналт тавин тэдгээрийг баталгаажуулах; 11. Гүйцэтгэгчийн гаргасан газрын түвшин, хөндлөн огтлолын зураг, геодезийн хэмжилтийн үр дүнг шалган баталгаажуулж, ажил гүйцэтгэх зөвшөөрөл өгөх; 12. Гүйцэтгэгчийн гаргасан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түр зам барих болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах төлөвлөгөөг хянаж, батлах; 13. Зөвлөх нь ажлын явцад Гүйцэтгэгчийн хийсэн ажлын тоо хэмжээг геодезийн болон бусад хэмжилтийн багаж ашиглан хянаж, тухай бүр тайлан гарган Захиалагчид ирүүлэх; 14. Замын далан, хөлдөлтөөс хамгаалах үе, суурийн доод ба дээд үе, хучлагын ажлын технологийн дараалал, өндрийн түвшин, үеийн нягтруулалт, гадаргуугийн хөндлөн хэвгий, тэгш байдлыг өдөр бүр шалгаж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрлийг бичгээр өгч байх; 15. Дугуй болон дөрвөлжин хоолой, төмөр бетон гүүр болон бусад ус зайлуулах байгууламжийн ажлыг хянан батлах; 16. Замын тэмдэг болон бусад тоноглолыг суулгахаас өмнө урьдчилан хянаж батлах; 17. Гүйцэтгэгчийн үйлдвэрлэж байгаа асфальтбетон болон бетон хольцны орц ба чанарт өдөр тутмын хяналт тавих; 18. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, ажил, ажиллах хүчний даатгалын гэрээг хянах; 19. Гүйцэтгэгч батлагдсан ажлын зураг, техникийн шаардлагын дагуу зөвшөөрөгдсөн материал, тоног төхөөрөмж ашиглан ажил гүйцэтгэх технологийн дагуу барилгын ажлыг явуулж байгаа эсэхэд өдөр тутам, байнгын хяналт тавих; 20. Гүйцэтгэгчийн ажлын зураг, материал, хийц хэсэг, тоног төхөөрөмж, ажлын аргачлал өөрчлөгдөх бүрт Зөвлөх тэдгээрийг хянаж Захиалагч болон Зохицуулах байгууллагатай зөвшилцөж зөвшөөрөл олгох; 21. Ажлын бус өдөр, амралтын цагаар болон илүү цагаар гүйцэтгэгч ажиллах хүсэлт гаргавал ажиллах үүрэгтэй; 22. Ажлын явцад ажлын зураг, техникийн шаардлага зөрчих, батлагдаагүй материал, тоног төхөөрөмж ашиглах, батлагдсан
--	---

	<p>аргачлалаас өөр аргаар ажил гүйцэтгэх бүрт Зөвлөх нь Гүйцэтгэгчийн ажлыг зогсоох эрх, үүрэгтэй. Ажил зогсоох шаардлагыг албан бичгээр өгнө.</p> <p>23. Зөвлөх нь долоо хоног, сарын эхээр Гүйцэтгэгчийг урин талбайн уулзалт хийх бөгөөд энэ уулзалтаар долоо хоногт болон сард төлөвлөсөн ажлын явц, гүйцэтгэл, ажлын чанар, ажлын графикийн өөрчлөлт зэрэг барилгын ажлын явцтай холбоотой асуудлуудыг хэлэлцэх ба уулзалт бүрийн тэмдэглэлийг хөтөлж байна. Онцгой нөхцөл байдал үүссэн тухай бүрд уулзалт зохион байгуулж болно.</p> <p>24. Зөвлөх нь аливаа асуудлыг Захиалагчаар дамжуулан холбогдох байгууллагуудтай албан бичгээр харилцан шийдвэрлэж байна.</p> <p>25. Гүйцэтгэгчийн хийсэн ажил нь чанарын шаардлага хангаагүй бол түүнийг дахин хийлгэх, засварлуулах зэрэг арга хэмжээг тухай бүрт авах бөгөөд ийм ажилд төлбөр хийгдэхгүй.</p> <p>26. Зөвлөх нь барилга, байгууламжийн ажилд ямар нэг өөрчлөлт гарахаар бол Захиалагчид танилцуулах эрх, үүрэгтэй боловч гэрээний үнийн дүнгийн тодорхой хувиас доош өртөг бүхий ажлын өөрчлөлтийг ФИДИК-ийн гэрээний дагуу бие даан шийдэх эрхтэй. Нарийвчилсан хувь болон Зөвлөхийн бусад эрх, үүргийг Захиалагч-Зөвлөхийн хооронд хийгдэх гэрээгээр зохицуулна.</p> <p>27. Гүйцэтгэгч гэрээний заалтуудыг зөрчиж, гэрээт хугацаандаа ажлаа дуусгаагүй бол Зөвлөх нь гэрээний зохих заалтын дагуу гэрээний торгууль ногдуулах санал гаргаж Захиалагчид танилцуулах үүрэгтэй бөгөөд торгууль ногдуулах асуудлыг Захиалагч шийдвэрлэн Зөвлөхөд мэдэгдэнэ.</p> <p>28. Гүйцэтгэгч гэрээт хугацаандаа ажлаа дуусгаж чадахгүй, ажлыг чанартай хийж гүйцэтгэх чадваргүй зэрэг асуудал тодорхой болсон нөхцөлд Зөвлөх нь гүйцэтгэгчийн гэрээг цуцлан өөр Гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч авах зэрэг саналаа Захиалагчид танилцуулна. Гэрээ цуцлах, өөр гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч нэмж авах асуудлыг Захиалагч шийдвэрлэнэ.</p> <p>29. Гүйцэтгэгч байгууллага ажлаа дуусган улсын комисст ажлаа хүлээлгэж өгсний дараа Зөвлөх нь ажил дууссан тухай гэрчилгээ бичиж, Захиалагчид хүргүүлнэ.</p> <p>30. Гүйцэтгэгчийн гэрээнд заасан баталгаат хугацаа дууссаны дараа Зөвлөх нь замын ашиглалтын байдлыг хянан үзэж, ажлын чанар муугаас болж гарсан эвдрэлийг Гүйцэтгэгчээр засуулан эцсийн гэрчилгээ бичиж барьцааны болон буцаах мөнгийг Гүйцэтгэгч байгууллагад эргүүлэн төлөх хүсэлтийг Захиалагчид гаргах;</p> <p>31. Баталгаат засварын хугацаа дуусах үед авто замын байдал болон Гүйцэтгэгчийн хийх шаардлагатай засварын ажлын талаар Захиалагчид танилцуулах;</p> <p>32. Барилгын ажил дууссаны дараа авто замыг хүлээж авахад Захиалагчид мэргэжлийн туслалцаа үзүүлэх;</p> <p>33. Авто замаар зорчсон тээврийн хэрэгслийн тоо, анхны төсөвт өртөг, урсгал зардал, болон бусад нотолгоонд үндэслэн тандалт</p>
--	--

	<p>судалгаа хийх, жил бүрийн тайлан гаргах; 34. Захиалагчтай өдөр тутам харилцаж бүх талын мэдээллээр хангах; 35. Захиалагчтай харилцан тохиролцсон бусад ажлууд;</p>
<p>Зөвлөхөд тавигдах шаардлага</p>	<p>Зөвлөхөд дараах шаардлагууд тавигдана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зөвлөх нь уг үйлчилгээг үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх ба авто замын барилгын ажилд байнгын хяналт тавих нэг багийг ажиллуулна. 2. Хяналтын багийн ажилтнуудын амьдрах байр, тэдгээрийн тавилга, хэрэгсэл, компьютер болон албан конторын бусад тоног төхөөрөмж, талбайд болон төвтэйгээ шуурхай холбоо барих хэрэгсэл, геодезийн багаж, ажлын хээрийн хувцас гэх мэт ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх ба тээвэр, холбоо, цахилгаан дулаан, бичиг хэрэг, хангамж болон бусад бүх зардлыг Зөвлөх өөрөө бүрэн хариуцна. 3. Авто замаар зорчсон тээврийн хэрэгслийн тоо, анхны төсөвт өртөг, урсгал зардал, болон бусад нотолгоонд үндэслэн тандалт судалгаа хийх, жил бүрийн тайлан гаргахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг Зөвлөх бүрэн хариуцаж, зохион байгуулна. 4. Хяналтын багийн ахлагч буюу Ерөнхий инженерээс бусад голлох мэргэжилтнүүд хэсгүүдэд зохион байгуулагдаж урьдчилан гаргасан ажлын хуваарийн дагуу барилгын ажлын талбайд байнга ажиллах шаардлагатай. 5. Хяналтын баг нь дор хаяж 10 голлох мэргэжилтнүүдтэй байх ба багт ажиллах ажилтны тоо үүгээр хязгаарлагдахгүй. Голлох мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд: <p>А. Ерөнхий инженер – 1 Ерөнхий инженер нь уг зөвлөх үйлчилгээг бүхэлд нь удирдан ажиллах бөгөөд зөвлөхийн ажлын үр дүнг Захиалагчийн өмнө бүрэн хариуцана. Ажлын талбайд ажиллах хэсгүүдийг болон уг зөвлөх үйлчилгээтэй холбоотойгоор оффист ажиллах ажилтнуудыг нэгдсэн удирдлагаар хангах бөгөөд ажлын талбайд байнга байх шаардлагагүй боловч сард нэгээс доошгүй удаа ажлын талбайд очиж ерөнхий хяналт тавих, төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх судалгаа хийж, тайлан бэлтгэж ажиллах үүрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын барилгын инженерийн магистр болон түүнээс дээш зэрэгтэй; - Мэргэжлээрээ 15-аас дээш жил, үүнээс 6-аас дээш жил зураг төсөл болон авто замын барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан; - Зөвлөх эсвэл мэргэшсэн инженерийн зэрэгтэй; - Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд технологийн хяналт хийх “Тэргүүн инженер”-ийн итгэмжлэлтэй; - Удирдах ажлын туршлагатай; <p>Б. Авто замын инженер буюу Хэсгийн ахлагч – 1 Хэсгийн ахлагч нь өөрийн хариуцан ажиллаж буй хэсэг дэх зөвлөх багийн мэргэжилтнүүдийн ажлыг өдөр тутмын</p>

	<p>удирдлагаар ханган, ажлын талбайд байнга ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй; - Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил, үүнээс 4-өөс дээш жил зураг төсөл болон авто замын барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан; - Зөвлөх эсвэл мэргэшсэн инженерийн зэрэгтэй; - Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд технологийн хяналт хийх "Ахлах инженер"-ийн итгэмжлэлтэй; - Удирдах ажлын туршлагатай; <p>В. Хиймэл байгууламжийн инженер – 1</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй; - Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас дээш жил зураг төсөл болон авто зам, гүүрийн барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан; - Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд технологийн хяналт хийх "Инженер"-ийн итгэмжлэлтэй; <p>Г. Материалын инженер – 2</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын барилгын эсвэл барилгын материалын инженерийн мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй; - Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас дээш жил авто замын барилгын материалын хяналтын чиглэлээр ажилласан туршлагатай; - Авто зам, гүүрийн барилга, засварын ажлын материалын хяналт тавих "Инженер"-ийн итгэмжлэлтэй; <p>Д. Хэмжилтийн инженер – 2</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын барилгын эсвэл геодезийн инженерийн мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй; - Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас дээш жил авто замын барилгын ажлын геодезийн хэмжилтийн чиглэлээр ажилласан туршлагатай; - Авто зам, гүүрийн барилга, засварын ажлын геодезийн хяналт тавих "Инженер"-ийн итгэмжлэлтэй; <p>Е. Тоо хэмжээний инженер – 1</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын барилгын инженерийн эсвэл инженер-эдийн засагч мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй; - Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас дээш жил авто замын барилгын ажлын тоо хэмжээний хяналтын чиглэлээр ажилласан туршлагатай; - Авто зам, гүүрийн мэргэшсэн төсөвчин байх; - Авто зам, гүүрийн барилга, засварын ажлын тоо хэмжээнд хяналт тавих "Инженер"-ийн итгэмжлэлтэй; <p>Ё. Байгаль орчны инженер - 1</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль орчны хамгаалал, хяналт, шинжилгээ, үнэлгээ, нөхөн сэргээлтийн аль нэг эсвэл тэдгээртэй адилтгах мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй; - Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн чиглэлээр 3-аас
--	--

	<p>доошгүй жил ажилласан туршлагатай;</p> <p>Ж. ХАБЭА-н инженер – 1</p> <ul style="list-style-type: none"> - ХАБЭА-н тусгай эрх бүхий сургалтын үнэмлэхтэй авто зам, барилгын инженер эсхүл ХАБЭА-н инженерийн мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй; - Авто замын эсхүл барилгын салбарт ХАБЭА-н чиглэлээр 3-аас дээш жил ажилласан байх; <p>6. Зөвлөх нь ажлыг шуурхай хянах, Гүйцэтгэгчийн ажлыг саатуулахгүй байх үүднээс Зөвлөх нь 2500 см3-ээс багагүй багтаамж бүхий 3-аас доошгүй авто машинтай байна.</p> <p>7. Зөвлөх нь үйлчилгээнд ашиглагдах хээрийн иж бүрэн лаборатори, хэмжилтийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байна.</p>
<p>Тайлангийн хуваарь</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эхлэлийн тайлан: Зөвлөх үйлчилгээний ажил эхэлсэнээс хойш 1 сарын дотор Захиалагчид хүргүүлнэ. 2. Сар, улирал тутмын явцын тайлан: Зөвлөх нь барилгын ажлын явцын тайланг сар бүр, улирал тутам гарган Захиалагчид ирүүлнэ. Тайланд барилгын ажлын явц, чанар байдал, ажлын явцад гарсан аливаа өөрчлөлтийн талаар, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох фото зураг, график, тооцооны хамт танилцуулна. 3. Гүйцэтгэлийн тайлан: Зөвлөх нь авто замын барилгын ажил дууссаны дараа гүйцэтгэлийн тайлан бичиж Захиалагчид хүргүүлнэ. 4. Нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн тайлан: Зөвлөх нь улсын комисс ашиглалтанд хүлээн авснаас эхлэн баталгаат хугацаа дуусах хүртэлх хугацаанд тухайн замаар зорчсон тээврийн хэрэгслийн тоо, анхны төсөвт өртөг, урсгал зардал, болон бусад нотолгоонд үндэслэн тандалт судалгаа явуулж, тухайн жилийн тайланг дараа жилийн нэгдүгээр сард багтаан Захиалагчид ирүүлнэ. 5. Төслийн эцсийн тайлан: Барилгын ажлын баталгаат хугацаа дуусгавар болсоноор авто замын барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ дуусгавар болсонд тооцон төслийн эцсийн тайлан бичиж Захиалагчид хүлээлгэн өгнө. <p>Зөвлөх нь Захиалагч болон Гүйцэтгэгчтэй монгол хэл дээр харилцах бөгөөд бүх тайлан, материалаа монгол хэл дээр бэлтгэн танилцуулна.</p>